



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 01 сарын 30 өдөр

Дугаар 5/19

Хэрлэн сум


Тэтгэмж олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Хөдөлмөрийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2, 58.2.17, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг Даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Хэнтий аймгийн музейн захирал Ц.Эрдэнэбулган нь эрүүл мэндийн байдлын улмаас Хөдөлмөрийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.2-т заасны дагуу үүрэгт ажлаасаа чөлөөлөгдсөн тул 6 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж олгосугай.

Хоёр. Тэтгэмжид шаардагдах 3.768.132 /гурван сая долоон зуун жаран найман мянга нэг зуун гучин хоёр/ төгрөгийг аймгийн Засаг даргын тэтгэмж урамшууллын зардлаас олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар /Ж.Ганбаатар/-т тус тус зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА